

Боловсруулалт хийгдэж байгаа

ИНД-174

Иргэний нисэхийн багц дүрэм

**Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага –
Гэрчилгээжүүлэлт**

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-174 нь дараах зохицуулалтыг хэрэгжүүлнэ:

- нисэхэд цаг уурын үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын гэрчилгээжүүлэлт ба үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт;

- нисэхэд цаг агаарын үндсэн мэдээний хангалт хийхэд тавигдах шаардлагууд.

Энэ баримт бичиг нь ИНЕГ-аас гаргасан мөрдөгдөж буй ИНД-174 дүрмийн бүрэн хувилбар бөгөөд зөвхөн лавлагаа хэлбэрээр ашиглахад зориулав. Зам, тээврийн сайдын баталсан дүрмээс хөрвүүлсэн болно. Зам, Тээврийн сайдын баталсан дүрэм, дүрмийн өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас авах эсвэл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авна.

Гарчиг

НИСЭХИЙН ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА – ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ	1
БҮЛЭГ А -ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	4
174.1 Үйлчлэх хүрээ	4
174.3 Тодорхойлолтууд	4
174.5 Цаг уурын үйлчилгээ - гэрчилгээжүүлэлт	5
174.6 Цаг агаарын үндсэн мэдээ.....	5
174.7 Гэрчилгээ эзэмших өргөдөл гаргах	5
174.9 Гэрчилгээ олгох.....	5
174.11 Гэрчилгээ эзэмшигчийн эрх.....	6
174.13 Гэрчилгээний хугацаа	6
174.15 Гэрчилгээний хугацааг сунгах	6
БҮЛЭГ В. ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД.....	6
174.51 Боловсон хүчинд тавигдах шаардлагууд.....	6
174.53 Ажлын талбарт тавигдах шаардлага	7
174.55 Холбооны системд тавигдах шаардлага	7
174.57 Мэдээ хүлээн авахад тавигдах шаардлага	8
174.59 Мэдээ түгээхэд тавигдах шаардлага	8
174.61 Байгууламжид тавигдах шаардлага.....	9
174.63 Баримт бичиг	9
174.65 Нягтлалт, давтамжит үзлэг, шалгалт, тохируулга.....	9
174.67 Цаг уурын мэдээллийг түгээхэд зөвшөөрөл олгох.....	10
174.69 Цаг уурын үйлчилгээний салбар, байгууламжийн талаарх мэдэгдэл	10
174.71 Осол, зөрчил гарсны дараа цаг уурын мэдээллийг шалгах	11
174.73 Гэмтэл, алдаатай мэдээлэл	11
174.75 Бүртгэл.....	11
174.77 Аюулгүй ажиллагааны удирдлага	12
174.79 Цаг уурын үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны заавар	12
БҮЛЭГ С. ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД.....	14
174.101 Шаардлагад үргэлжлүүлэн нийцүүлэх.....	14
174.103 Үйл ажиллагааны журам.....	15
174.105 Хүчингүй болсон.....	15
174.107 Гэрчилгээ эзэмшигчид тавигдах хязгаарлалтууд.....	15
174.109 Гэрчилгээ эзэмшигч байгууллагад өөрчлөлт хийгдэх.....	15
174.111 Аюулгүй ажиллагааны үзлэг ба аудит	16
174.151 Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч болон өргөдөл гаргагчийн шилжилтийн үе.....	17
174.153 Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч болон өргөдөл гаргагчийн шилжилтийн үеийн дотоод чанар баталгаажуулалт.....	18

БҮЛЭГ А -ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

174.1 Үйлчлэх хүрээ

ИНД-174 нь дараах зохицуулалтыг хэрэгжүүлнэ:

- (1) нисэхэд цаг уурын үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын гэрчилгээжүүлэлт ба үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт;
- (2) нисэхэд цаг агаарын үндсэн мэдээний хангалт хийхэд тавигдах шаардлагууд.

174.3 Тодорхойлолтууд

Энэ дүрэмд:

"Цаг агаарын үндсэн мэдээ" гэж нисэхийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор тухайлсан талбар, эсхүл агаарын зайд ажиглагдсан тухайн үеийн цаг агаарын дараах байдлын талаарх амаар хийсэн тайлбарыг:

- (1) салхины чиглэл, хүч;
- (2) далайн түвшний агаарын даралтын дундаж утга;
- (3) агаарын температур;
- (4) цаг агаарын нөхцөл ба үүлшилт;

"Цаг уурын алдаатай мэдээлэл" гэж тухайн мэдээний зөвшөөрөгдөх нарийвчлал, тохиргооноос ихээхэн хэмжээгээр хэтэрсэн байж болохуйц цаг уурын аливаа мэдээллийг;

"Байгууламж " гэж цаг уурын байгууллагын үйл ажиллагаанд, эсхүл цаг агаарын мэдээг автоматаар хангадаг бөгөөд дараах үйл ажиллагаанд ашигладаг аливаа систем, тоног төхөөрөмжийг хэлнэ:

- (1) цахим өгөгдлөөр дүн шинжилгээ ба урьдчилсан мэдээ болвсруулдаг;
- (2) цаг агаарыг зайнаас тандан судлах;
- (3) цаг уурын мэдээг цахим, эсхүл автоматаар дамжуулах;

"Цаг уурын мэдээлэл" гэж нисэхийн үйл ажиллагааг дэмжихэд зориулсан аливаа цаг уурын мэдээ, дүн шинжилгээ, урьдчилсан мэдээг, мөн нисэхийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор тухайн үеийн, эсхүл ирээдүйн цаг уурын нөхцлийг илэрхийлсэн мэдэгдлүүдийг;

"Цаг уурын үйлчилгээний салбар" гэж цаг уурын үйлчилгээ үзүүлдэг, дэмжлэг үзүүлдэг нэгжийг, эсхүл цаг уурын мэдээллийг нэгтгэх, үүсгэх, хэрэглэгчдэд түгээх үүрэгтэй нэгжийг;

"Цаг уурын мэдээ" гэж нисэхийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор тухайлсан цаг, байрлалд цаг уурын нөхцөл байдалд ажиглалт хийж гаргасан мэдэгдлийг;

"Цаг уурын үйлчилгээ" гэж нисэхийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор цаг уурын мэдээллээр хангаж байгаа дараах үйлчилгээний аль нэгийг:

- (1) уур амьсгалын үйлчилгээ: тухайлсан газар нутаг, эсхүл агаарын зайн тухайлсан хэсэгт уур амьсгалын мэдээллийг боловсруулах, хангах үйлчилгээ;

- (2) Урьдчилсан мэдээгээр үйлчилгээ: тусгайлсан газар нутаг, эсхүл агаарын зайн тухайлсан хэсэгт цаг уурын урьдчилсан мэдээллээр хангах үйлчилгээ;
- (3) Мэдээлэл түгээх үйлчилгээ: цаг уурын мэдээллийг цуглуулах ба түгээхтэй холбоотой үйлчилгээ;
- (4) Цаг уурын зөвлөмж өгөх үйлчилгээ: цаг уурын тухайн үеийн болон ирээдүйн төлөвийг илэрхийлсэн нөхцөл байдал, цаг уурын мэдээллийг бичгээр болон амаар танилцуулах үйлчилгээ;
- (5) Цаг уурын мэдээний үйлчилгээ: цаг уурын мэдээгээр тогтмол хугацаагаар хангах үйлчилгээ;
- (6) Цаг уурын хяналт тавих үйлчилгээ: тусгайлсан бүс нутагт агаарын хөлгийн үйл ажиллагаанд нөлөөлөх цаг уурын нөхцөлд хяналт тавих үйлчилгээ.

174.5 Цаг уурын үйлчилгээ - гэрчилгээжүүлэлт

- (a) Энэ дүрмийн дагуу цаг уурын үйлчилгээ үзүүлэх гэрчилгээ эзэмшээгүй аливаа этгээд нисэхийн цаг уурын үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.
- (b) ИНЕГ-ын дарга нь Монгол улсын агаарын навигацийн системтэй харилцан холбогдох зорилгоор цаг уурын байгууллагуудын сүлжээн дээр суурилсан цаг уурын нэг үйлчилгээнээс эхлээд иж бүрэн үйлчилгээ үзүүлэх эрхийг олгосон гэрчилгээг олгож болно.

174.6 Цаг агаарын үндсэн мэдээ

Цаг агаарын үндсэн мэдээгээр хангаж буй ажилтан бүр нь:

- (1) цаг агаарын ажиглалт хийхэд тохиромжтой тоног төхөөрөмж ашиглах;
- (2) тоног төхөөрөмжийг шалгадаг тогтолцоотой байх;
- (3) цаг агаарын үндсэн мэдээгээр хангах сургалтанд хамрагдсан байх.

174.7 Гэрчилгээ эзэмших өргөдөл гаргах

Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь ИНЕГ-24174/ 01 маягтыг бөглөж дараах баримт бичгийн хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ:

- (1) 174.79 заалтаар шаардсан үйл ажиллагааны заавар;
- (2) хуульд нийцүүлэн баталсан дүрэм, журмуудад тогтоосон өргөдлийн хураамж төлсөн баримт бичиг.

174.9 Гэрчилгээ олгох

ИНЕГ-ын дарга нь дараах шаардлагуудыг хангасан гэж үзвэл өргөдөл гаргагчид цаг уурын үйлчилгээний гэрчилгээ олгоно:

- (1) өргөдөл гаргагч нь Б бүлгийн шаардлагуудыг хангаж байгаа;

(2) өргөдөл гаргагч, түүний удирдах албан тушаалтнууд, 174.51-ийн (а)-гийн (1), (2)-т заасан ажилтнууд нь тохирох, зөв хүн гэж үзэж байгаа;

(3) гэрчилгээ олгох нь нисэхийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзэж байгаа.

174.11 Гэрчилгээ эзэмшигчийн эрх

- a) Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ нь тухайн гэрчилгээ эзэмшигчийн ажиллуулах эрх олгосон байгууламжийн төрлийг зааж өгнө.
- b) Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь өөрийн гэрчилгээнд заасан цаг уурын үйлчилгээг энэ дүрмийн 174.107 заалтад нийцүүлэн үзүүлнэ. Энэ үйлчилгээг үзүүлэхдээ цаг уурын үйлчилгээ бүр, цаг уурын үйлчилгээ бүрт үзүүлж байгаа цаг уурын мэдээлэл, цаг уурын үйлчилгээ бүрт хамрагдах нутаг дэвсгэр, агаарын зай нь тухайн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан байх ёстой.

174.13 Гэрчилгээний хугацаа

- (a) Цаг уурын үйлчилгээний гэрчилгээг 5 хүртэл жилийн хугацаагаар олгох ба сунгаж болно.
- (b) Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ нь хүчинтэй хугацаа дуусах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл хүчинтэй байна.
- (c) Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хугацаа дууссан, хүчингүй болсон бол гэрчилгээг ИНЕГ-ын даргад даруй хүргүүлнэ.
- (d) Цаг уурын үйлчилгээний гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлсэн бол эзэмшигч нь холбогдох баталгаажуулалт хийлгүүлэхийн тулд гэрчилгээг ИНЕГ-ын даргад даруй хүргүүлнэ.

174.15 Гэрчилгээний хугацааг сунгах

- (a) Цаг уурын үйлчилгээний гэрчилгээний хугацааг сунгуулах өргөдлийг ИНЕГ24171/01 маягтын дагуу гаргана.
- (b) Өргөдлийг гэрчилгээн дээр заасан сунгуулах хүсэлт гаргах хугацаа дуусах өдрөөс өмнө, ийм өдөр заагаагүй бол гэрчилгээний хугацаа дуусахаас дор хаяж 30 хоногийн өмнө ИНЕГ-ын даргад ирүүлнэ.

БҮЛЭГ В. ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

174.51 Боловсон хүчинд тавигдах шаардлагууд

- (a) Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь дараах албан тушаалтныг хөдөлмөрийн гэрээгээр, гэрээт ажилтнаар, бусад хэлбэрээр ажиллуулна:
 - (1) гүйцэтгэх захирал. Өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт тусгасан цаг уурын үйлчилгээ бүрийг санхүүжүүлэх, үйл ажиллагааны шаардлага, энэ дүрэмд заасан шаардлага ба стандартад нийцүүлэх эрх мэдэл бүхий албан тушаалтан;

- (2) гүйцэтгэх захиралд шууд захирагдах удирдах албан тушаалтнууд:
- (i) өргөдөл гаргагч байгууллага нь үйл ажиллагааны заавартаа нийцэж үйл ажиллагаагаа явуулж байгааг баталгаажуулах ажлыг хариуцсан;
 - (ii) 174.77-д заасан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо хариуцсан;
- (3) цаг уурын байгууллага, байгууламжийн төлөвлөлт, үйл ажиллагаа, хяналт, үзлэг, гэрчилгээжүүлэлт болон өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт тусгасан цаг уурын үйлчилгээг үзүүлэхэд хүрэлцэхүйц тооны ажилтнууд.

(b) дээрх (a)(2)(ii) заалтад дурдсан удирдах албан тушаалтнууд нь аюулгүй ажиллагааны тогтолцооны удирдлага болон гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаатай холбоотой зохих ур чадвар, туршлагатай болохыг нотолно.

(c) Өргөдөл гаргагч нь дараах журмыг тогтооно:

- (1) дараах ажлыг гүйцэтгэхээр өргөдөл гаргагчийн томилсон этгээдийн ур чадварыг үнэлэх журам:
- (i) өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт заасан байгууламжуудыг ашиглалтад авах;
 - (ii) цаг уурын мэдээллийг боловсруулах, түгээх үйл ажиллагаанд хяналт тавих;
- (2) эдгээр эрх бүхий ажилтнуудын ур чадварыг хадгалах журмыг тогтоох;
- (3) эдгээр эрх бүхий ажилтнуудад эрх мэдлийн хүрээг тогтоосон баримт бичиг олгох.

174.53 Ажлын талбарт тавигдах шаардлага

Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь дараах нөхцлийг баталгаажуулсан журмыг тогтооно:

- (1) үйл ажиллагааны зааварт тусгасан цаг уурын үйлчилгээний салбар, байгууламж бүр нь:
- (i) хууль бус, санаатай бус хөндлөнгийн нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд зориулсан аюулгүй байдлын арга хэмжээнд нийцүүлсэн байрлал, тохиргоотой байх;
 - (ii) үйлчилгээний тасалдалгүй байдлыг хангах цахилгаан тэжээлийн хангамжтай байх;
- (2) үйл ажиллагааны зааварт тусгасан цаг агаарыг зайнаас тандан мэдрэх байгууламж бүрийг тухайн газар орны цаг агаарын нөхцөлийг нарийвчлалтай, үнэн зөв харуулах техникийн шаардлага хангасан байрлалд суурилуулах ба засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж байх.

174.55 Холбооны системд тавигдах шаардлага

- (a) Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь үйл ажиллагааны зааварт тусгасан цаг уурын үйлчилгээний салбар, байгууламж бүр тухайн зориулалтаар үйлдвэрлэгдсэн, цаг уурын мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн холбооны систем, журамтай байна.
- (b) Холбооны систем, журам нь цаг уурын мэдээллийн хэмжээ ба төрлөөс үл хамааран дамжуулдаг байх ба дамжуулалтын хугацааны хоцрогдлоос шалтгаалж мэдээлэл нь хуучрахгүй байхыг баталгаажуулсан байна.

174.57 Мэдээ хүлээн авахад тавигдах шаардлага

- (a) Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч бүр нь өөрийн үзүүлэх цаг уурын үйлчилгээнд шаардлагатай цаг уурын мэдээллийг хүлээн авах журмыг тогтооно.
- (b) Тус журам нь дараах зүйлсийг баталгаажуулна:
 - (1) өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт заасан цаг агаарын урьдчилсан мэдээгээр хангах үйлчилгээ эрхлэх цаг уурын үйлчилгээний салбар, байгууламж бүр нь цаг агаарын урьдчилсан мэдээгээр үйлчлэх бүсэд хамаарах олон жилийн дундаж, бодит ажиглалт, бусад цаг уурын мэдээлэлд байнгын холболттой байх;
 - (2) өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт заасан цаг уурын мэдээний зөвлөмжийг биечлэн, дэлгэцээр идэвхтэй харилцаа үүсгэж өгөх үйлчилгээ эрхлэх цаг уурын үйлчилгээний салбар, байгууламж бүр нь цаг уурын зөвлөмж өгөхөд тохиромжтой дэлгэц, бусад тоноглолоор тоноглогдсон байх;
 - (3) өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт заасан цаг уурын мэдээний үйлчилгээ эрхлэх цаг уурын үйлчилгээний салбар, байгууламж бүр нь тохиромжтой, нарийвчлалтай, цаг хугацаанд нь цаг уурын мэдээллээр хангахын тулд бодит ажиглалтын системтэй байх;
 - (4) өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт заасан цаг уурын хяналтын үйлчилгээ эрхлэх цаг уурын үйлчилгээний салбар, байгууламж бүр нь тохиромжтой, нарийвчлалтай, цаг хугацаанд нь цаг уурын мэдээллээр хангахын тулд цаг уурын зохих мэдээллээр хангагддаг байх;
 - (5) өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт заасан уур амьсгалын мэдээний үйлчилгээ эрхлэх цаг уурын үйлчилгээний салбар, байгууламж бүр нь уур амьсгалын мэдээллийг бэлтгэхэд шаардлагатай цаг уурын мэдээллээр хангагддаг байх.

174.59 Мэдээ түгээхэд тавигдах шаардлага

- (a) Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч бүр нь:
 - (1) өөрийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан цаг уурын үйлчилгээ бүрээс түгээх цаг уурын мэдээллийг нарийвчлан ангилах;
 - (2) түгээж буй цаг уурын мэдээлэлд тавигдах стандарт, форматыг тодорхойлох.

- (b) Өргөдөл гаргагч нь үйл ажиллагааны зааварт тусгагдсан цаг уурын үйлчилгээний салбар, байгууламж бүрийн хангаж байгаа цаг уурын мэдээлэл нь дээрх (a) (2)-т тодорхойлсон стандарт, форматад нийцэж байгааг хянах журмыг тогтооно.

174.61 Байгууламжид тавигдах шаардлага

Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч бүр нь цаг уурын мэдээллийг цуглуулах, нэгтгэх, тооцоолох, нэвтрэх, түгээхэд ашигладаг цахим өгөгдөл боловсруулах бүх байгууламжууд цаг уурын болон бусад мэдээллийг зохистой, нарийвчлалтай, хугацаанд нь дамжуулах зориулалтын, зохих бүтэц, чадвартай болохыг баталгаажуулах журмыг тогтооно.

174.63 Баримт бичиг

- (a) Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч бүр нь үйл ажиллагааны зааварт тусгагдсан цаг уурын үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай цаг уурын үйлчилгээний салбарын журам, байгууламжийн заавар, техникийн стандарт ба зөвлөмж, үйл ажиллагааны заавар, бусад баримт бичгийн хувийг хадгална.
- (b) Өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (a)-д дурдсан баримт бичгийг хянах журмыг тогтооно. Энэ журам нь дараах зүйлсийг агуулна:
- (1) баримт бичгийг түгээхээс өмнө эрх бүхий албан тушаалтан хянаж зөвшөөрсөн байх;
 - (2) үйл ажиллагааны зааварт заасан цаг уурын үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай бүх баримт бичгийн хүчин төгөлдөр хувийг авч ашиглах боломжийг бүх ажлын байран дахь ажиллагчдад олгосон байх;
 - (3) баримт бичиг нь хүчингүй болмогц түгээсэн, ашиглаж байгаа бүх байрлалаас даруй устгах;
 - (4) баримт бичигт хийгдсэн өөрчлөлтийг холбогдох албан тушаалтан хянаж, баталгаажуулах;
 - (5) хүчин төгөлдөр бус хувийг ашиглахаас сэргийлэхийн тулд баримт бичгийн хүчинтэй хувь нь ялгагдахуйц байх.

174.65 Нягтлалт, давтамжит үзлэг, шалгалт, тохируулга

- (a) Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч бүр нь дараах журмыг тогтооно:
- (1) өргөдөл гаргагчийн хүлээж авсан ба түгээж байгаа цаг уурын мэдээллийг тогтмол нягтлах;
 - (2) өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан цаг уурын үйлчилгээний салбар бүрт давтамжит үзлэг хийх;
 - (3) өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан байгууламж бүрт давтамжит үзлэг, шалгалт, тохируулга хийх.
- (b) Эдгээр журам нь дараах зүйлсийг баталгаажуулна:

- (1) цаг уурын мэдээллийг тогтмол нягтлах ажиллагаанд шаардлагатай систем нь хүрэлцэхүйц багтаамж ба харилцан холбогдож ажиллах чадвартай байх;
- (2) цаг уурын үйлчилгээний салбар бүрт үзлэг хийх ажилтнууд нь үзлэгийн зохих тоног төхөөрөмж, системээр хангагдсан байх;
- (3) байгууламж бүрт үзлэг, шалгалт, тохируулга хийх ажилтнуудыг үзлэг, хэмжилт, шалгалт хийх зохих тоног төхөөрөмж, системээр хангах;
- (4) үзлэг, хэмжилт, шалгалт хийх тоног төхөөрөмж, систем нь тухайн үзлэг, хэмжилт, шалгалт хийхэд шаардагдах нарийвчлал, чадвартай байх;
- (5) иж бүрдэлд орсон, эсхүл нэмж холбосон байгаль орчны мэдрэгчүүд нь найдвартай, нарийвчлалтай ба төлөөлөхүйц цаг уурын мэдээллийг өгдөг байхыг баталгаажуулахын тулд цаг уурын мэдрэгч бүхий бүх байгууламжид тохируулга, тохиргоог хийдэг байх.

174.67 Цаг уурын мэдээллийг түгээхэд зөвшөөрөл олгох

- (a) Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь дараах журмыг тогтооно:
 - (1) өөрийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан цаг уурын үйлчилгээний салбар бүрээс цаг уурын мэдээллийг гаргах зөвшөөрөл;
 - (2) өөрийн үйл ажиллагааны зааварт тусгасан байгууламжуудыг ашиглалтад оруулах зөвшөөрөл;
- (b) Эдгээр журмуудад цаг уурын мэдээллийг боловсруулах ба гаргахад хяналт тавих эрх бүхий ажилтнууд, мөн түүнчлэн цаг уурын байгууламжуудыг ашиглалтад оруулах эрх бүхий ажилтнуудыг энэ дүрмийн 174.51-ийн (b)-д заасан журамд нийцүүлэн үнэлэж, чадвараа хадгалж байгааг баталгаажуулдаг тогтолцоог тусгасан байна.

174.69 Цаг уурын үйлчилгээний салбар, байгууламжийн талаарх мэдэгдэл

- (a) Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь цаг уурын үйлчилгээний хэрэглэгчиддээ үйл ажиллагааны мэдээлэл, мөн өөрийн үйл ажиллагааны зааварт тусгасан цаг уурын үйлчилгээний салбар, байгууламжуудын мэдээлэл ба үйл ажиллагаанд гарсан аливаа өөрчлөлтийн талаар мэдэгдэл хүргүүлдэг байх журмыг тогтооно.
- (b) Өргөдөл гаргагч нь дээрх (a)-д заасан журмууд нь дараах шаардлагыг хангасан болохыг баталгаажуулна:
 - (1) өргөдөл гаргагчийн Монгол Улсын агаарын навигацийн систем, агаарын хөдөлгөөний үйлчилгээг явуулахад дэмжлэг үзүүлдэг цаг уурын үйлчилгээ бүрийн үйл ажиллагааны мэдээллийг Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP)-д хэвлүүлэх зорилгоор нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагад хүргүүлэх;
 - (2) цаг уурын үйлчилгээний салбар, байгууламжийн үйл ажиллагаанд агаарын навигацийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөхүйц өөрчлөлт

гарсан бол нэн даруй үйлчлүүлэгчиддээ мэдэгдэл хүргүүлдэг байх. Монгол улсын Нисэхийн мэдээллийн эмхэтгэлд хамрагдсан цаг уурын үйлчилгээний салбар, байгууламжид гарсан үйл ажиллагааны өөрчлөлтийн мэдэгдлийг NOTAM гаргуулах зорилгоор нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ.

174.71 Осол, зөрчил гарсны дараа цаг уурын мэдээллийг шалгах

- (a) Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч бүр нь осол, зөрчилд холбогдсон агаарын хөлөг, агаарын хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын ашигласан байж болох өөрийн түгээсэн цаг уурын мэдээллийн тохирол, нарийвчлал, цаг хугацааг шалгах журмыг тогтооно.
- (b) Энэ журам нь дараах зүйлсийг баталгаажуулна:
 - (1) осол, зөрчил гарсан тухай тухайн өргөдөл гаргагч байгууллагад мэдэгдсэний дараа нэн даруй нягтлан шалгалтыг гүйцэтгэх;
 - (2) цаг уурын мэдээллийн хувиудыг шинжлэн шалгах ажиллагаанд ашиглахад бэлэн байлгах зорилгоор найдвартай газар хадгалах.

174.73 Гэмтэл, алдаатай мэдээлэл

Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь дараах журмыг тогтооно:

- (1) цаг уурын алдаатай мэдээллийн түгээлтийг илрүүлэх, бүртгэх, мэдэгдэх, шинжлэн шалгах, шүүн хэлэлцэж алдааг залруулах;
- (2) цаг уурын алдаатай мэдээллийг гаргах шалтгааны үүсгэгч байж болох өөрийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан байгууламж болон цаг уурын үйлчилгээний дутагдлыг илрүүлэх, бүртгэх, мэдэгдэх, шинжлэн шалгах, шүүн хэлэлцэж алдааг залруулах;
- (3) цаг уурын алдаатай мэдээллийг хүлээн авсан бүх үйлчлүүлэгчдэд нэн даруй мэдэгдэх;
- (4) 72 цагийн дотор засаж залруулах боломжгүй гэмтлийн талаар ИНЕГ-ын даргад 12 цагийн дотор мэдэгдэх;
- (5) ИНЕГ-ын дарга шаардвал тухайн гэмтэлтэй байгаа хугацаанд нөхцөл байдлаа илтгэж байх.

174.75 Бүртгэл

- (a) Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь үйл ажиллагааны зааварт тусгасан цаг уурын үйлчилгээгээр хангахад шаардлагатай бүртгэлийг ангилах, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, арчлах, устгахтай холбоотой журмыг тогтооно.
- (b) Энэ журам дараах зүйлсийг баталгаажуулна:
 - (1) 174.57 заалтын дагуу тогтоосон журмаар хүлээн авсан цаг уурын мэдээллийг бүртгэх;
 - (2) 174.59 заалтын дагуу түгээсэн цаг уурын бүх мэдээллийг бүртгэх;

- (3) дээрх (b) (1), (2) заалтуудад дурдсан бүртгэлийг дор хаяж 60 хоног хадгалах ба хэрэв ИНЕГ-ын дарга энэ хугацаанаас илүү хугацаагаар хадгалахыг шаардсан бол тухайн хугацааг мөрдөх;
- (4) өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны зааварт тусгагдсан цаг уурын үйлчилгээний салбар, байгууламж бүрт бүртгэл хөтөлж цаг уурын үйлчилгээний салбар, байгууламж бүрийн гүйцэтгэл, техникийн засвар үйлчилгээ, бүтээгдэхүүний чанар, тэдгээрт хийгдсэн давтамжит үзлэгүүд, эдгээр ажил тус бүрийг гүйцэтгэсэн, хариуцсан ажилтнууд зэргийг эргэж тогтоох боломжтой байхыг баталгаажуулна.
- (5) 174.65 заалтын дагуу тогтоосон журамд нийцүүлэн хийсэн нягтлалт, үзлэг, шалгалт, тохируулгад ашигласан тоног төхөөрөмж, системийн бүртгэлийг хөтлөнө. Бүртгэл нь тухайн тоног төхөөрөмж, системийн байршил, ашиглалт үйлчилгээ, тохируулгын шалгалт зэргийг мөрдөн тогтоох боломжтой байх;
- (6) 174.73 заалтын дагуу тогтоосон журмын дагуу илрүүлсэн цаг уурын алдаатай мэдээлэл, байгууламжийн гэмтэл бүрийн бүртгэлийг хөтөлнө. Энэ бүртгэл нь цаг уурын алдаатай мэдээлэл, гэмтлийн төрөл, шинжлэн шалгалтын явцад илрүүлсэн дутагдлууд, залруулах арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг агуулах;
- (7) хүчингүй болсон;
- (8) өргөдөл гаргагчийн цаг уурын мэдээллийг боловсруулах, гаргах ажиллагааг хянах эрх бүхий этгээд, байгууламжийг ашиглалтад хүлээн авах эрх бүхий этгээдийн бүртгэлийг хөтөлнө. Бүртгэлд тэдгээрийн ажлын туршлага, мэргэшил, сургалт, олгогдсон эрхийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй хамруулах;
- (9) бүх бүртгэл нь гаргацтай, хадгалалт даахуйц байх;
- (10) дээрх (b) (1), (2) заалтуудад зааснаас бусад бүх бүртгэлийг цаг уурын үйлчилгээний гүйцэтгэлийн түүхийг үүсгэх зорилгоор дор хаяж 1 жил, ИНЕГ-ын дарга шаардвал, түүний шаардсан хугацаагаар хадгална.

174.77 Аюулгүй ажиллагааны удирдлага

Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь ИНД100.3 дүрэмд нийцүүлэн аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжүүлэх, арчлах ажлыг зохион байгуулна.

174.79 Цаг уурын үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны заавар

- (a) Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь дараах мэдээллийг агуулсан үйл ажиллагааны зааврыг ИНЕГ-ын даргад хүргүүлнэ:
 - (1) үйл ажиллагааны заавар, бусад зааврууд нь дараах зүйлсийг агуулсан болохыг баталгаажуулж өргөдөл гаргагч байгууллагын өмнөөс гүйцэтгэх захирлын гарын үсэг зурсан мэдэгдэл:
 - (i) байгууллагын тодорхойлолт, энэ дүрэмд хэрхэн нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах арга барил;

- (ii) байнга нийцүүлж ажиллах байдал;
- (2) 174.77 заалтад заасан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоотой холбогдуулан:
- (i) ИНД100.3(b) заалтаар шаардсан бүх бүх баримт бичгүүд;
 - (ii) цаг уурын үйлчилгээний гэрчилгээний хугацаагаа сунгуулах өргөдөл гаргагчаас бусад этгээдийн хувьд аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө;
- (2) 174.51(a) (1), (2) заалтад заасан албан тушаалтан, ажилтнуудын нэр, албан тушаал;
- (3) 174.51(a) (1), (2) заалтад заасан албан тушаалтан, ажилтнуудын дараах асуудлыг хамруулсан үүрэг, хариуцлагын хуваарилалтын мэдээлэл:
- (i) тухайн байгууллагын нэрийн өмнөөс ИНЕГ-ын даргатай шууд харилцах асуудлууд;
 - (ii) аюулгүй ажиллагааны удирдлагад хүлээх хариуцлага;
- (4) 174.51(a)(1), (2) заалтад заасан албан тушаалтан, ажилтнуудын үүрэг, хариуцлагыг харуулсан байгууллагын бүтэц, зохион байгуулалтын бүдүүвч зураг;
- (5) (a)(7)(i) заалтад дурдсан цаг уурын үйлчилгээний салбар бүр дэх өргөдөл гаргагчийн боловсон хүчний бүтэц, нэгтгэсэн мэдээлэл;
- (6) байгууллага доторх аюулгүй ажиллагааны хариуцлагын хязгаарыг харуулсан мэдээлэл;
- (7) гэрчилгээний хүрээнд зөвшөөхөгдсөн цаг уурын үйлчилгээнүүдийн жагсаалт;
- (8) энэ жагсаалт нь дараах зүйлсээс бүрдэнэ:
- (i) өргөдөл гаргагчийн үйлчилгээ үзүүлж буй цаг уурын үйлчилгээний салбар бүрийн байршил;
 - (ii) өргөдөл гаргагчийн хэрэглэгчдэд цаг уурын мэдээллээр шууд хангадаг байгууламж бүрийн байршил;
 - (iii) тэдгээр цаг уурын үйлчилгээний салбар, байгууламж бүрийн үзүүлдэг цаг уурын үйлчилгээнүүд;
 - (iv) тэдгээр цаг уурын үйлчилгээнд хамрагдаж буй нутаг дэвсгэр ба агаарын зай;
- (9) 174.59 (a)(1) заалтад заасан өргөдөл гаргагчийн цаг уурын мэдээллийг түгээх талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, 174.59 (a)(2) заалтад тодорхойлсон мэдээллүүдийн стандарт, форматууд;
- (10) дараах заалтуудаар шаардсан өргөдөл гаргагчийн журмууд болон системийн талаарх нарийвчилсан мэдээлэл:
- (i) 174.51(b) заалтаар шаардсан ажилтнуудын ур чадвар;
 - (ii) 174.53 заалтаар шаардсан ажлын талбарт тавигдах

шаардлагууд;

- (iii) 174.55 заалтаар шаардсан холбоонд тавигдах шаардлагууд;
- (iv) 174.57 заалтаар шаардсан цаг уурын мэдээ хүлээн авахад тавигдах шаардлагууд;
- (v) 174.59 заалтаар шаардсан цаг уурын мэдээ түгээхтэй холбоотой шаардлагууд;
- (vi) 174.61 заалтаар шаардсан байгууламжид тавигдах шаардлагууд;
- (vii) 174.63(b) заалтаар шаардсан баримт бичгийн хяналтад тавигдах шаардлагууд;
- (viii) 174.65 заалтаар шаардсан нягтлалт, үзлэг, шалгалт, тохируулгад тавигдах шаардлагууд;
- (ix) 174.67 заалтаар шаардсан цаг уурын мэдээллийг түгээх зөвшөөрөл, байгууламжийг ашиглалтад хүлээн авахад тавигдах шаардлагууд;
- (x) 174.69 заалтаар шаардсан цаг уурын үйлчилгээний салбар, байгууламжийн талаар мэдээлэл түгээхэд тавигдах шаардлагууд;
- (xi) 174.71 заалтаар шаардсан осол, зөрчлийн мэдээлэл ирсний дараа цаг уурын мэдээллийг нягтлахад тавигдах шаардлагууд;
- (xii) 174.73(a) заалтаар шаардсан гэмтэл, алдаатай мэдээллийг шалгахад тавигдах шаардлагууд;
- (xiii) 174.75 заалтаар шаардсан бүртгэлийг ангилах, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, арчлах, устгахад тавигдах шаардлагууд;

(11) үйл ажиллагааны зааврыг хянах, өөрчлөх ба түгээх журам.

(b) Өргөдөл гаргагчийн үйл ажиллагааны заавар нь ИНЕГ-ын даргад хүлээн зөвшөөрөгдөхүйц байна.

БҮЛЭГ С. ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

174.101 Шаардлагад үргэлжлүүлэн нийцүүлэх

Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч бүр нь:

- (1) үйл ажиллагааны зааварт заагдсан цаг уурын үйлчилгээний салбар бүрт үйл ажиллагааны зааврын хүчин төгөлдөр, иж бүрэн нэгээс доошгүй хувийг байршуулсан байх;
- (2) үйл ажиллагааны зааварт тусгагдсан бүх журам болон системд нийцэж үйл ажиллагаа явуулдаг байх;
- (3) ажилтны ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах үйл ажиллагааны зааврын хамааралтай хэсгүүдийг ашиглахад бэлэн байхаар байршуулах;
- (4) энэ дүрмийн гэрчилгээжүүлэлттэй холбоотой Б бүлэгт заасан

шаардлагуудыг мөрдөх, мөн стандартуудад байнга нийцүүлэх;

- (5) ИНЕГ 24174/01 маягтаар шаардсан байгууллагын хаяг, утас, факсын дугаар өөрчлөгдөх тохиолдолд ИНЕГ-ын даргад 28 хоногийн дотор мэдэгдэх.

174.103 Үйл ажиллагааны журам

Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч бүр нь өөрийн үйл ажиллагааны заавартаа тусгасан цаг уурын үйлчилгээний салбар бүртээ үйл ажиллагааны журам боловсруулж мөрдөнө. Үйл ажиллагааны журам нь цаг уурын үйлчилгээний салбар, холбогдох байгууламжуудын ажиллагаа ба техник үйлчилгээнд тавигдах шаардлагыг тодорхойлж өгөх ба дараах жагсаалтыг хамарна:

- (1) хангаж буй цаг уурын мэдээлэл, үзүүлж буй цаг уурын үйлчилгээ;
- (2) байгууламжид тавигдах ажиллагааны хүлээн зөвшөөрөх хамгийн бага үзүүлэлтүүд ба стандартууд;
- (3) цаг уурын хүлээн авах мэдээний хамгийн бага үзүүлэлт;
- (4) цаг уурын мэдээ ба үйлчилгээнээс түгээх мэдээлэлд тавигдах гүйцэтгэл ба чанарын хамгийн бага үзүүлэлт;
- (5) дээрх (4) дэд заалтын дагуу гаргасан жагсаалтын хамгийн бага түвшний хэмжилтэд шаардагдах шалгалтын тоног төхөөрөмж ба системүүд;
- (6) цаг уурын мэдээллийг гаргахдаа заавал гүйцэтгэх аливаа хяналтын журам.

174.105 Хүчингүй болсон

174.107 Гэрчилгээ эзэмшигчид тавигдах хязгаарлалтууд

Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигчид дараах зүйлсийг хориглоно:

- (1) түгээх цаг уурын мэдээллийг боловсруулахад ашиглах ёстой цаг уурын мэдээлэл ирээгүй байхад цаг уурын мэдээллээр хангах;
- (2) цаг уурын үйлчилгээний салбар, байгууламжийн үйл ажиллагааны гүйцэтгэл нь холбогдох шаардлагад нийцэхгүй байхад тэдгээрээс гарсан цаг уурын мэдээллийг ашиглах;
- (3) цаг уурын мэдээлэлтэй холбоотой нэгдсэн хяналтын систем нь бүрэн ажиллахгүй үед цаг уурын мэдээллээр хангах;
- (4) цаг уурын мэдээлэлтэй хамааруулж шаарддаг нягтлалт, үзлэг, шалгалт, тохируулгыг бүрэн гүйцэтгээгүй үед цаг уурын мэдээллээр хангах;
- (5) цаг уурын мэдээллийн нэгдсэн хяналтын бүрэн ажиллагаанд аливаа эргэлзээ гарсан үед цаг уурын мэдээллээр хангах.

174.109 Гэрчилгээ эзэмшигч байгууллагад өөрчлөлт хийгдэх

- (a) Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч нь өөрийн байгууллага ба хангаж буй цаг уурын үйлчилгээнд хийсэн өөрчлөлтийг үйл ажиллагааны заавартаа тухай бүрт нь оруулна.
- (b) Гэрчилгээ эзэмшигч нь өөрийн үйл ажиллагааны заавартаа оруулсан аливаа өөрчлөлт нь энэ дүрмийн шаардлагад нийцсэн болохыг баталгаажуулах ба өөрийн үйл ажиллагааны зааварт тусгасан өөрчлөлт оруулах журмыг дагаж мөрдөнө.
- (c) Гэрчилгээ эзэмшигч нь өөрийн үйл ажиллагааны заавартаа өөрчлөлт оруулах бүртээ хувийг ИНЕГ-ын даргад нэн даруй хүргүүлнэ.
- (d) Гэрчилгээ эзэмшигч нь дараах өөрчлөлтийг оруулахын өмнө ИНЕГ-ын даргад урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авна:
 - (1) гүйцэтгэх захирал;
 - (2) жагсаалтад орсон удирдах ажилтнууд;
 - (3) гэрчилгээ эзэмшигчийн үзүүлж буй цаг уурын үйлчилгээ;
 - (4) гэрчилгээ эзэмшигчийн цаг уурын үйлчилгээний салбар бүрийн хамаарч буй нутаг дэвсгэр ба агаарын зай;
 - (5) хэрэв материаллаг өөрчлөлт оруулж байгаа бол аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо.
- (e) дээрх (d)-д дурдсан аливаа өөрчлөлтүүдийг хийх, хийсний дараа үйл ажиллагаандаа мөрдөх тусгай нөхцлийг ИНЕГ-ын дарга шаардаж болно.
- (f) Гэрчилгээ эзэмшигч нь дээрх (e)-д заасны дагуу ИНЕГ-ын дарга тусгай нөхцөл шаардсан бол дагаж мөрдөнө.
- (g) Энэ дүрэмд дурдсан аливаа өөрчлөлт нь гэрчилгээнд өөрчлөлт оруулах шаардлагыг бий болговол гэрчилгээ эзэмшигч гэрчилгээгээ ИНЕГ-ын даргад нэн даруй хүргүүлж өөрчлөлтийг тусгуулна.
- (h) ИНЕГ-ын дарга нь нисэхийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс аливаа өөрчлөлтийг гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны зааварт оруулахыг шаардвал тус өөрчлөлтийг даруй оруулна.

174.111 Аюулгүй ажиллагааны үзлэг ба аудит

- (a) ИНЕГ-ын дарга нь нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах үүднээс гэрчилгээ эзэмшигчийн цаг уурын үйлчилгээний салбар, байгууламж, баримт бичиг, бүртгэлд үзлэг, аудит хийлгэхийг цаг уурын үйлчилгээ үзүүлэх гэрчилгээ эзэмшигчид **Иргэний нисэхийн тухай хуулийн 15 дугаар заалтын** дагуу бичгээр ирүүлж болно.
- (b) ИНЕГ-ын дарга нь цаг уурын үйлчилгээ үзүүлэх гэрчилгээ эзэмшигчээс үзлэг, аудиттай холбоотой мэдээллийг ирүүлэхийг шаардаж болно.

174.151 Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч болон өргөдөл гаргагчийн шилжилтийн үе

- (a) Энэ хэсэг нь дараах этгээдэд хамаарна:
 - (1) цаг уурын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч;
 - (2) цаг уурын үйлчилгээний гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч.
- (b) 2018 оны 2-р сарын 1-нээс өмнө, энэ хэсэг хамаарах байгууллага:
 - (1) дараах шаардлагыг биелүүлэхийг шаардахгүй:
 - (i) хэрэв аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтны оронд тухайн байгууллагад дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан ажиллаж байгаа бол энэ дүрмийн 174.51 (a)(2)(ii) заалтыг;
 - (ii) хэрэв аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог үүсгэх, хэрэгжүүлэх, ажиллуулахын оронд тухайн байгууллагад энэ дүрмийн 174.153 -д нийцсэн дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо байгаа бол энэ дүрмийн 174.77 заалтыг;
 - (iii) 174.79 (a)(2) заалтыг;
 - (iv) 174.79 (a)(3)(ii) заалтыг;
 - (v) 174.79 (a)(5A)(ii) заалтыг; гэхдээ дараах шаардлагыг биелүүлэх:
 - (2) 2016 оны 7 дугаар сарын 30-наас өмнө ИНЕГ-ын зохих маягтыг бөглөж дараах зүйлсийг тусгасан хэрэгжүүлэх төлөвлөгөөний хамт ИНЕГ-ын даргад хүргүүлнэ:
 - (i) аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж эхлэх төлөвлөсөн огноо;
 - (ii) 174.77-д шаардсан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх тухайн байгууллагын төлөвлөгөөний тайлбар.
- (c) ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрөх боломжтой гэж үзвэл:
 - (1) тухайн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах;
 - (2) аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх өдрийг тогтоох.
- (d) Эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх өдөр гэдэг нь ИНЕГ-ын даргын тогтоосон өдөр байна.
- (e) 174.151(c)(2) заалтад нийцүүлэн өдрийг тогтоохдоо ИНЕГ-ын дарга нь дараах зүйлсийг харгалзана:
 - (1) тухайн байгууллагын чадамж;
 - (2) тухайн байгууллагын үйл ажиллагааны олон талт байдал;
 - (3) тухайн байгууллагын үйл ажиллагааны эрсдлүүд;
 - (4) гэрчилгээний хугацаа сунгах огноо;

- (5) тухайн байгууллага, ИНЕГ, эсхүл хоёулангийнх нөөц бололцоо, цагийн хуваарьт нөлөөлөх байдал;
- (6) хэрэгжүүлэх хугацаа нь 2018 оны 2 дугаар сарын 1-нээс хойшгүй байна.
- (f) Хэрэв байгууллага нь цаг уурын үйлчилгээний гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч бол гэрчилгээ хүссэн өргөдөлдөө аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх төлөвлөгөөг хавсаргаж ирүүлнэ.
- (g) Энэ хэсэг 2018 оны 2 дугаар сарын 1-нд хүчингүй болно.

174.153 Цаг уурын үйлчилгээний гэрчилгээ эзэмшигч болон өргөдөл гаргагчийн шилжилтийн үеийн дотоод чанар баталгаажуулалт

- (a) 174.151(b)(1)(i) заалтаар шаардсан дотоод чанар баталгаажуулалтын системийг үүсгэн байгуулж энэ дүрмээр шаардсан журмуудад нийцүүлэх ба байгууллагын үйл ажиллагаагаа зохицуулна.
- (b) Дотоод чанар баталгаажуулалтыг хариуцсан удирдах ажилтан нь цаг уурын мэдээллийн нийцэл, нарийвчлал, цаг хугацаатай холбоотой асуудлаар гүйцэтгэх захиралтай шууд харьцах боломжтой байна.
- (c) Энэ хэсэг 2018 оны 2 дугаар сарын 1-нд хүчингүй болно.